Төрийн албаны зөвлөлийн 2019 оны
7 дугаар сарын 24-ний өдрийн 7/.. дугаар
тогтоолын 13 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☑ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Аймаг дахь Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | ..................... аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл** |
| Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга | Ахлах түшмэл, ТЗ-10 |
| **Ажлын цаг** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдрийн 8 цаг | |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, орон зайн мэдээллийн менежмент, барилга, хот байгуулалтын салбарын талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, чиг үүргийн хүрээнд ажлын гүйцэтгэлийн үр дүнг агентлагын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үндэсний хэмжээний урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө болон салбарын хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гарах хэм хэмжээний актын боловсронгуй болгоход санал өгөх, тэдгээрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.Хот, байгуулалтын баримт, бичиг боловсруулах, геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах.

3.Засгийн газраас баталсан тусгаг, масштабт зураглах, хэлбэр хэмжээг тодорхойлох, газар, байгалийн нөхцөл, нөөцийн иж бүрэн мэдээлэлтэйгээр нутаг дэвсгэр дэх газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах, газар зохион байгуулалт хийх, газар эзэмших, ашиглах эрхийг газар ашиглалтын зориулалт бүрээр бүртгэх, байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, боловсруулах, хүн амын нутагшилт суурьшил, бүс нутаг, хот суурины газрын төлөвлөлтийг боловсруулах, хот байгуулалтын кадастрыг хариуцан явуулах, хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх, экспертүүдийг сонгон шалгаруулахтай холбоотой үйл ажиллагааг эрхлэх.

4.Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, төсвийн удирдлага болон төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийг хэрэгжүүлэх.

5.Мэргэжлийн боловсон хүчний бодлогыг орон нутгийн хэмжээнд эрхлэж, хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг удирдан зохион байгуулах.

6.Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үйл ажиллагаа, сумын газрын даамлуудын гүйцэтгэлийн тайлан, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт хяналт, шинжилгээ үнэлгээ хийх, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах.

7.Геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, кадастр, хот байгуулалтын кадастр, орон зайн мэдээллийн нэгдсэн сангийн чиглэлээр олон нийтэд үйлчилгээ үзүүлэх, сурталчилах ажлыг зохион байгуулах.

8.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г, Хянах–Х, Шийдвэрлэх–Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Салбарын талаар төрөөс баримтлах бодлого, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд санал өгөх, аймаг, орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна. | Г, Х,Ш |
| | 2.Салбарын талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрхлэх, орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, туршлага судлах ажлыг зохион байгуулах; | Судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байна. | Г, Х,Ш |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 3.Салбарын урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусах арга хэмжээг боловсруулах, санал өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байна. | Г, Х,Ш |
| | 4.Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд салбарын талаарх арга хэмжээг боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; | Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байна. | Г, Х,Ш |
| | 5.Салбарын хууль болон тэдгээрт нийцүүлэн гарах захиргааны хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулахад санал өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна. | Г, Х,Ш |
| | 6.Салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан, судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байна. | Г, Х,Ш |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөлтэй, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэлт гаргах, авах арга хэмжээг тодорхойлох; | Зохицуулалт нь хууль болон ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байна. | Г,Х |
| | 2.Хот, байгуулалтын баримт бичиг боловсруулах, геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга, барилгын материалын үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрөл, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйгээр хангах, орон нутгийн хэмжээнд мэдээллийн сан үүсгэж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах; | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна. | Г,Х |
| | 3.Улсын төсөв болон орон нутаг, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ /барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засварын ажил/-ний ажлын явцад захиалагчийн хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах | Захиалагчийн техник хяналтыг тавьж, батлагдсан төсөвт багтаан, цаг хугацаанд ашиглалтад оруулсан байна. | Г, Х, Ш |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Геодезийн бүх төрлийн сүлжээ байгуулах, шинэчлэх, байр зүйн болон сэдэвчилсэн тоон зургаар хангах, хаягжуулах, мэдээллийн сан үүсгэх, нутаг дэвсгэрийн хэлбэр хэмжээг тогтоох геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | Геодези, зураг зүйн тухай хууль тогтоомжид нийцсэн байна. | Г, Х, |
| | 2.Аймгийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ байгуулж, мониторинг, хянан баталгааны үр дүнд суурилсан газар хамгаалах, нөхөн сэргээх | Суурь судалгаа болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа мониторингийн | Г, Х, |



МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| | | | |
|---|---|---|---|
| | үйл ажиллагаатай холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх; | мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байна. | |
| | 3.Иргэд, олон нийтийн оролцоо, салбар хоорондын уялдаа холбоог хангасан, геологи, хүрээлэн буй орчны төлөв байдал, байгалийн нөхцөл, нөөцийн иж бүрэн мэдээлэлд суурилсан тогтвортой газар ашиглалтыг төлөвлөх, аймгийн хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх, хяналт тавих, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн сан, системийг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах; | Газар зохион байгуулалтын мэдээллийн сангийн нэгдсэн системийн хэрэглээ, түүний хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна. | Г, Х, |
| | 4.Аймгийн нутаг дэвсгэр дээрх эдлэн газар, үл хөдлөх хөрөнгө, нөхцөл байдал, кадастрын хэмжилт, зураглал, хаягжилт, бүртгэлээр баталгаажуулах, байрлал бүхий үл хөдлөх хөрөнгийн иж бүрэн мэдээллийн сан, хувийн хэрэг, газрын бирж, үнийн мэдээ, үнэлгээ, төлбөр, татварын тогтолцоог сайжруулж, төрийн нэрийн өмнөөс хэрэглэгчийг баталгаат мэдээллээр хангах ажлыг хэрэгжүүлэх; | Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн хэрэглээ, түүний хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна. | Г, Х, |
| | 5.Нийгэм, эдийн засгийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтыг суурь орон зайн мэдээлэл, үйлчилгээгээр дэмжих, олон нийтэд түгээх, салбарын орон зайн өгөгдлийн дэд бүтцийн болон мэдээллийн технологийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах, | Мэдээ, мэдээлэл, ил тод нээлттэй хүрсэн байна. | Г, Х, |
| | 6.Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах, ашиглалтад хяналт тавих, бүртгэх, паспортжуулах ажлыг зохион байгуулах, орон нутагт барилгын материалын чанар, сорил шинжилгээний лабораторийг байгуулах, ажиллуулах; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | |
| | 7.Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшил, бүс нутаг, хот суурин газрын хөгжлийг төлөвлөх, мэдээлийн сан үүсгэх, хот байгуулалтын баримт бичигт экспертизийн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х, |
| | 8.Хот байгуулалтын кадастрыг хот, суурин газарт эрхлэх, зохиогчийн хяналт хийх, зохион байгуулах; | Хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх зүйн мэдлэг дээшилж, оролцоо нэмэгдэнэ. | Г, Х, Ш |
| | 9.Барилга байгууламжийг /шинээр барих, засварлах, өргөтгөх, шинэчлэх/ ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулахад холбогдох хууль тогтоомж, дүрэмд заасны дагуу ажиллах; | Норм, стандартын шаардлага хангасан байх | Г, Х, |
| | 10.Улсын төсөв болон орон нутаг, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ /барилга, | Захиалагчийн техник хяналтыг тавьж, батлагдсан төсөвт | Г, Х, Ш |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| | | | |
|---|---|---|---|
| | байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засварын ажил/-ний ажлын явцад захиалагчийн хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах; | багтаан, цаг хугацаанд ашиглалтад оруулсан байна. | |
| | 11.Салбарын нууцын зэрэглэлд хамаарах зураг, баримт, тоон мэдээллийн нууцлалыг чанд сахиж, хууль тогтоомжийн дагуу Тагнуулын Ерөнхий газар, Архивын Ерөнхий газар болон архив, нууцын чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; | Холбогдох хууль, журам хэрэгжсэн байна. | Г, Х |
| | 12.Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж захиргааны ерөнхий асуудлаар хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна. | Г, Х,Ш |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, зардлыг төсвийн хүрээний мэдэгдэл, төсөвт тусгуулах саналаа холбогдох байгууллагад хүргүүлэх; | Төсвийн төсөл судалгаа, шинжилгээнд тулгуурласан байна. | Г, Х, Ш |
| | 2.Батлагдсан төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих ажлыг хэрэгжүүлэх; | Төсвийн үргүй зардал гаргаагүй байна. | Г, Х, Ш |
| | 3.Байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулж холбогдох байгууллагад хүргүүлэх; | Үнэн, зөв мэдээллийг бэлтгэн хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. | Г, Х, Ш |
| | 4.Орон нутгийн төсөв бүрдүүлэх, орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох, тайлагнах; | Хууль тогтоомжоор тогтоож өгсөн тариф, нормативыг мөрдлөг болгосон байна. | Г, Х, Ш |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.Байгууллагын хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавхи дээшилсэн байна. | Г, Х, Ш |
| | 2.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл, газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; | Бусад салбар геодези, зураг зүйн чиглэлээр ойлголт мэдлэгтэй болсон байна. | Г, Х, Ш |
| | 3.Байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах; | Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаанд бодит үр гарсан байх. | Г, Х, Ш |
| 6 дугаар зорилтын хүрээнд | 1.Байгууллагын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх, үнэлгээний мөрөөр авах арга хэмжээг авах ажлыг зохион байгуулах; | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна. | Г, Х, Ш |
| | 2.Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааны хэрэгжилт, сумын газрын даамлуудын гүйцэтгэлийн тайлан, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хяналт, шинжилгээ | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна. | Г, Х, Ш |



МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| | | | |
|---|---|---|---|
| | үнэлгээ хийх, дүгнэлт өгөх, ажлыг зохион байгуулах; | | |
| | 3.Сумын газрын даамлуудын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах; | Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байна. | Г, Х, Ш |
| | 4.Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран орон нутгийн хэмжээнд салбарын чиглэлээр хяналт, шинжилгээ үнэлгээний баг, ажлын хэсэгт ажиллах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах; | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна. | Г |
| 7 дугаар зорилтын хүрээнд | 1.Орон нутагт газрын харилцааны салбар (геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалт, хаяг, орон зайн мэдээллийн дэд бүтэц)-ын мэдээллийн нэгдсэн сан, системийг бий болгож, баталгаат мэдээллээр иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг гүйцэтгэх; | Орон зайн мэдээллийн сангийн шаардлагыг хангасан байна. | Г, Х, Ш |
| | 2.Орон нутагт газрын харилцааны салбар (геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалт, хаяг, орон зайн мэдээллийн дэд бүтэц)-ын мэдээллийн сан, системд бүртгэгдэж буй өгөгдөл, мэдээлэлд чанарын хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх; | Холбогдох журмын дагуу үйлчилгээ авсан иргэн, хуулийн этгээд баталгаат мэдээлэл авсан байна. | Г, Х, Ш |
| | 3.Орон нутгийн хэмжээнд хийгдсэн судалгаа, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилт, зохион байгуулсан арга хэмжээ, хүрсэн үр дүн, мэдээллийн сангийн талаар олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах; | Олон нийтэд зөв, бодитой мэдээллийг хүргэсэн байна. | Г, Х, Ш |
| 8 дугаар зорилтын хүрээнд | 1.Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах; | Байгууллагын үндсэн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлэх. | Г |
| | 2.Төсвийн шууд захирагчийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагчтай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулах, биелэлтийг хангах; | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна | Г |
| | 3.Батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан, орон тоо, цалингийн санг тогтоох; | Орон тооны дээд хязгаарт багтаан, цалингийн сан, төсөв хэтрээгүй байна. | Г |
| | 4.Хууль тогтоомжид заасны дагуу албан хаагчдыг албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тугаалаас бууруулах, өөр албан шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халах, бүрэн эрхэд хамаарах бусад асуудлаар тушаал гаргах; | Бүрэн эрхийг хэтрүүлэхгүй, хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлсэн байна. | Г |
| | 5.Эрхэлсэн асуудлаараа дээд шатны байгууллага болон Нийслэлийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын | Үнэн зөв, бодит мэдээ, мэдээллээр хангагдсан байна. | Г |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН ... ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | даргад мэргэшлийн зөвлөгөө өгөх, холбогдох мэдээллээр хангах; | | |
| | 6.Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг боловсронгуй болгох, үйл ажиллагаандаа мөрдүүлэх; | Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байна. | Г |
| | 7.Байгууллагыг төлөөлж бусад байгууллагатай харилцах; | Ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна. | Г |
| | 8.Харъяалах дээд шатны байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгавар, Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурал, удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, биелэлтийг хангах; | Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна. | Г |
| | 9.Байгууллагын дотоод дүрэм, журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх; | Дүрэм, журм ёс зүйн хэм хэмжээнд заасан манлайлал бий болсон байна. | Г |

**III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА**

| | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | -газар зохион байгуулалт /менежмент, төлөвлөлт/;<br>-газрын кадастр /үнэлгээ/;<br>-геодези /геодези, инженер геодези, сансрын геодези;<br>-астрономи, агаарын зураглал/;<br>-барилга /барилга, ус, дулаан хангамж, цахилгааны инженер/;<br>-хот байгуулалтын кадастр;<br>-архитектор;<br>-хот төлөвлөгч. | |
| Мэргэшил | -эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;<br>-тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн инженерийн зэрэгтэй байх. | |
| Туршлага | Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | - гүйцэтгэлд тогтмол хяналт тавих<br>- албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах<br>- эрх мэдэл ба харилцааны түвшинг тодорхойлох<br>- эргэх холбоотой байх, албан хаагчдын санал, бодлыг нь сонсох<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах<br>- бусад |
| | Дүн шинжилгээ хийх | - мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийх,<br>- үр дүнг харьцуулан үнэлэх, тайлбарлах<br>- бодлогын хувилбар боловсруулах<br>- бусад |
| | Асуудал шийдвэрлэх | - асуудлыг хууль болон ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх<br>- асуудалд дүн шинжилгээ хийх<br>- асуудлыг шийдвэрлэх зорилгоо томьёолох<br>- асуудлыг шийдвэрлэх хувилбарыг тогтоож, эерэг, сөрөг үр дагаврыг харьцуулах<br>- асуудлыг шийдвэрлэх зөвлөмж боловсруулах |



МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРӨВ

| | | |
|---|---|---|
| | | - бусад |
| | Манлайлах | - үүссэн асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг сонгох<br>- санаачлагатай байж, бүтээлчээр уриалан чиглүүлэх<br>- нөөц боломж, эрч хүчээ дайчлахад нь дэмжлэг үзүүлэх<br>- хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, халамжлах зэргээр үлгэрлэх<br>- байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах<br>- цагийн менежмент сайтай байх<br>- бусад |
| | Бусад | - газар зүйн мэдээллийн системийн arcgis, quantum gis гэх мэт програм хангамжийг эзэмшсэн байх<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах<br>- багаар ажиллах чадвартай байх<br>- бусад |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга
- Аймгийн Засаг дарга

| Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: |
|---|---|
| - Хэлтсийн дарга<br>- Ахлах мэргэжилтнүүд<br>- Мэргэжилтнүүд<br>- Төрийн үйлчилгээний ажилтнууд<br><br>Нийт: | 1. Төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах<br>2. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай харилцах<br>3. Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал:<br><br>АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА<br><br>………………………… .А.БАТБАЯР<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2019 оны 08 сарын 20ны өдөр | Байгууллагын нэр:<br><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><br>Шийдвэрийн огноо: 19 07 24<br><br>Дугаар: 41 |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

## VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2019 .08. 20

Дугаар: 187
(тамга/тэмдэг)

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА...........................Ц.ГАНХҮҮ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2019 оны 08 дугаар сарын 20-ны өдөр

МОНГОЛ УЛС
ЗӨВШӨӨРӨВ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ